

ӨНДӨР ГЭГЭЭНТЭН БА МОНГОЛЫН ТҮҮХ БИЧЛЭГ

З.Лонжид
Монгол улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх ухааны сургууль, Түүхийн тэнхим

Өгүүллийн товч утга: Өндөр гэгээн Занабазарын намтар үйл ажиллагааг Монголын түүхчид судалсан байдал; судалгаанд гарсан ахиц өөрчлөлт; цаашид анхаарч үзүүштэй зүйлийг судлан хөндсөн болно.

Түлхүүр үг: Улсын шастир боловсруулах; Өндөр гэгээний одон; Богд Жибзундамба хутагтын 23-н дүрийн түүх; Зарлигаар тогтосон Монгол улсын шастир; Ар Элстэйн чуулганы шийдвэр; Түүх бичгийн цоорхой
Нэрс: Чингис, Далай лам, Банчин-Эрдэнэ, Номын Богд, Энх-Амгалан хаан, Ш.Нацагдорж, Ш.Бира, сойвон Шаравдорж, Локеш Чандра, Н.Сонинбаяр_ Или Тарвагатай.

Монголын эх түүхийн алтан хуудаснаа мөнхөрсөн алдар суут хүмүүсийн нэг бол Жибзундамба хутагтын арван зургаа дахь дүрээр тодорсон Халхын Занабазар байлаа. Таван настайгаасаа эхлэн Монголчуудын итгэл бишрэлийг хүлээх болсон тэр суут хутагтын тухай судалгаанд үе үеийн түүхчид олон бүтээл туурвилаа зориулжээ. Түүнийг анхдугаар Богдын дүрд тодруулсан 1650-иад оноос эхлээд 1929 он хүртэлх 200 гаруй жилийн туршид Монголын түүхчдийн ялангуяа номын их мэргэдийн бүтээл туурвилд түүний тухай заавал дурсан өгүүлдэг байжээ. Харин 1929 оноос эхэлсэн зүүнтний их хийрхлийн уршгаар Монголын түүхт хүмүүсийн нэр алдрыг зориуд харлуулан гутаах болж, нэг үзэл суртлын чанд шалгуур хэмжүүрт бүх зүйлийг захируулах, тохируулахыг хичээж эзэн Чингис түүний дараах хаад ноёд, бурхан шашны нэрт зүтгэлтнүүдийн тухай хэн ч ам ангайх эрхгүй шахам болсон билээ. Гэвч итгэл бишрэлдээ чин үнэнч монголчууд өндөр гэгээнтний тухай огт мартаагүйгээр үл барам түүний номлол сургаалаас эцэг, эх нь үр ач нартаа эрдэмтэй, ухаалаг багш нар нь шавь сурагчиддаа зааж уламжлуулсаар 1990 оны ардчилал, шинэчлэлтэй золгосноор монголчууд улирч өнгөрсөн түүхээ нэхэн тодруулах гүнзгийрүүлэн судлах боломж нээгдсэнээр Өндөр гэгээнтний тухай шинжилгээнд нэгэн шинэ үе эхэлсэн юм.

Сүүлийн 15 жилийн хугацаанд манай эх түүхийн шинжилгээний нэг салбар нь нэрт хүмүүсийн намтрын судалгаа болж, нэлээд бүтээл хэвлэгдсэний дотор Өндөр гэгээнтэн судлалд шууд ба дам хамаарах зүйл цөөнгүй байна. Цаашид ч энэ талын судалгаа улам эрчимжиж гүнзгийрэх нь лавтай. Иймээс урьд өмнө нь юу хийсэн бэ гэдгийгээ эргэж харах нь зайлшгүй хэрэгцээ болж байгаа учир би энэхүү өгүүлэлдээ манай түүхчид 1911 оноос эдүгээ хүртэл хугацаанд Өндөр гэгээнтний улс төрийн үйл

ажиллагааг судалсан байдлыг тоймлон өгүүлэх болно. Тэгэхдээ нилээд даацтай судалгаа буюу томоохон бүтээлд тулгуурлаж бэлтгэсэн бодол эргэцүүллээ эрдэмтэн та бүгдэд толилуулж санал бодлоо хуваалцахыг хичээлээ.

Өгүүлэхүй нь: 1911 онд Монгол улс төрийн тусгаар тогтнолоо сэргээн тунхаглаж, засгийн яамд байгуулахдаа Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яаманд улсын шастир боловсруулах, түүнд холбогдох аливаа хэргийг даалган хариуцуулсан байна. Иймээс ч тус яам алдар суут хүмүүсийнхээ дурсгалыг мөнхжүүлэх, түүх намтрыг нь туурвихад анхаарч дэс дараа бүхий хэд хэдэн ажил хэрэгжүүлсэн юм. Тухайлбал 1912 онд эзэн хаантан ДХБЗШЯ-наас өргөсөн саналыг соёрхож буулгасан зарлиг ёсоор Монгол улсын төрийн эрхэм дээд шагнал "Эрдэнийн очир" хэмээх гурван зэрэг, арван хоёр дэс бүхий (1-р зэрэг нь 3, дэд зэрэг нь 4, 3-р зэрэг нь 5 дэстэй) одон бий болгосны тэргүүн зэргийн одонгийн нэгдүгээр дэсийг Чингис хааны одон, хоёрдугаар дэсийг Автайсайн ханы, гуравдугаар дэсийг Өндөр гэгээний одон гэж нэрлэсэн байна. (30.3) Эдгээр одонг монголын төлөө сайн үйл бүтээсэн гадаадын ба өөрийн улсын иргэдэд шагнаж хүртээж байжээ.

Үүнээс гадна эзэн хааны зарлигаар 1913-1918 онд боловсруулсан "Монгол улсын хууль зүйлийн бичиг"-ийн 34-р дэвтэрт Өндөр гэгээнтний тухай онцлон тэмдэглэж, тэрбээр Монгол оронд *"Бурханы шашныг дэлгэрүүлэн хамаг амьтныг тусалж, халхын олон монголчуудыг тэргүүлэн авч, манж монгол овогтныг найралдуулан зохиож гайхамшиг явдлыг илэрхийлсэн"* (16.136) хэмээн дурджээ. Мөн 1913-1919 онд хаантны зарлигаар туурвисан Монгол улсын албан түүх буюу "Зарлигаар тогтоосон Монгол улсын шастир" хэмээх арван нэгэн дэвтэр зохиолд Энх-Амгалангийн 27-р он буюу 1688 оноос 1919 оны арваннэгдүгээр сарын шинийн есөн хүртэлх хугацаанд халх монголд болсон гол гол үйл явдлыг хаад ноёдын намтраар дэвсгэрлэн өгүүлсэн байдаг. Энэхүү шастрын эхний таван дэвтрийг Богд Жибзундамба хутагтын хорин гурван дүрийн түүх намтарт зориулсан бололтой. (22.11.83, 27.31) Харамсалтай нь тэрхүү таван дэвтэр одоогоор олдохгүй байна. Бодоход 1929 оноос эхлэн олон жил үргэлжилсэн улс төрийн хямралын цөвүүн цагт хэт хувьсгалчид түүхийн тэрхүү үнэт өвийг хуучны бурангуй суртал хэмээн устгасан байж тун магадгүй. Харин тус шастрын төгсгөлийн арваннэгдүгээр дэвтэрт *"Түшээт хан Гомбо(Гомбодорж З.Л.)-ын хоёрдугаар хөвгүүн болон Тугдан хувилгаан гарч бүх халхчуудад тахигдсан Богд Жибзундамба блама юугаан халхчууд бүгдээр нийлж*

бат оршил өргөөд бэлгэтэй ёсоор морь уралдуулан, бөх барилдуулан, сур харвуулан ийм гурван зүйл наадмыг тахил болгон өргөсөн” (22.83) тухай өгүүлээд Галдангийн самууны үед “Жибзундамба ламтан бүх халхчуудыг авч Манж улсын хаанаа тулгар дагаар орсныг сайшааж... Далай блама, Банчин эрдэнэ дэслэн үеийн үед халх дахины их ширээнд суух их лам багш болгон өргөмжлөөд умар зүгийн амьтны итгэл, номын Богд хэмээн магтаан шүлэглэл ба шашныг мандуулах, амьтныг жаргуулагч цол, алтан тамга, алтан навчит өргөмжлөл шагнан өгч халх дахинаа шарын шашныг өргөн дэлгэрүүлэхийн эш суртахууныг даатгаж, ямагт тэнхрүүлэн халхчууд бүгдээрийн багш болгон тахиглан шүтүүлсэн”(22.84) хэмээн өндөр гэгээнтнийг монголын эх түүхэнд мөнхөд тэмдэглэгдэх учиртайг тэрхүү шастир боловсруулан үйлдсэн эрдэмтэд сайн мэдэж байсны нотолгоо буюу.

1911-1919 он бол монголын түүхийн маш хүнд бэрх үе байсан боловч төр засаг эх түүхээ нэхэн туурвих ялангуяа суут хүмүүсийнхээ намтар үйл ажиллагааг өргөн олонд сурталчлахад онцлон анхаарч байсны нотолгоо нь саяын дурдсан гурван баримтаас тодорхой байна. 1919-1921 он бол Монгол орон улс төрийн гүнзгий хямралд өртөж, түмэн олон хэтийн хувь заяаныхаа төлөө эрслэн босч тэмцсэн зурвас үе бөгөөд үүний үрээр Монголын шинэ эрин эхэлж ард түмэн эрх чөлөөгөө олж, улс орныхоо бүрэн эрхт эзэн болсон юм.

Үүнээс хойш буюу 1921 оны үндэсний хувьсгалын ялалтаас эхлэн монголчууд улирсан түүхээ сэргээн туурвих боломж бүрдэж, бэсрэг ном, өгүүлэл нийтлэгдэж байлаа. Гэхдээ Өндөр гэгээнтний тухай нийтэд зориулсан бүтээл төдий л гараагүй бололтой. Харин 1954 оноос эхлэн хэвлэгдэж байгаа хамтран зохиогчдын бүтээл болох Монгол улсын түүх зохиолын хэд хэдэн удаагийн хэвлэлд Өндөр гэгээнтний тухай товч боловч дурдсан байна. 1954 онд Монгол-Зөвлөлтийн эрдэмтдийн хамтран туурвисан “БНМАУ-ын түүх”-ийн анхны хэвлэлд Өндөр гэгээнтний тухай хэдэн мөр зүйл өгүүлэхдээ түүнийг 1635 онд төрж, 1641 онд монголын шарын шашны хувилгаанаар өргөмжлөгдөж, 1724 онд нас барсан хэмээн түүхэн он цагийг нягтлалгүй дурдсан төдийгүй 1691 онд Дол нуурын чуулган дээр “Халхын ихэнх ноёд Жибзундамбын шаардлагаар Манжийн харъяат” (7.200) болжээ. Жибзундамбын дараагийн дүрүүд “цөм монголын ард түмний эсэргүү харгис хүчнийг оройлох болжээ” (7.200) хэмээн монголын шашны тэргүүнээр удаа дараа өргөмжлөгдсөн

хутагтууд бүгдээрээ монголчууд ба монгол төрийн эсрэг үйл ажиллагаа явуулж байсан мэтээр дүгнэсэн байна.

Энэхүү нэг боть зохиолоос хойш манай түүхчид Өндөр гэгээнтний тухай судалгаанд төдий л анхаарахаа больж, аль болохоор зайлсхийх хандлагатай байлаа. Харин академич Ш.Нацагдорж энэ талаар туршлагатай судлаач хүний байр суурьтай байсныг зориуд цохон тэмдэглэж байна. Тэрбээр 1962 онд хэвлүүлсэн томоохон суурь бүтээлдээ гэгээнтний тухай хоёр үндсэн санаа дэвшүүлсэн юм. Үүнд нэгдүгээрт халхын ноёд Өндөр гэгээнтнийг монголын шарын шашны тэргүүнээр өргөмжилсөн нь *"халх монголын улс төрийн амьдралд маш их учир холбогдолтой зүйл болсон билээ"* (24.35) хэмээн тэмдэглээд манжийн хаад Эеэр засагч, Энх-Амгалан нарын аль аль нь *"Өндөр гэгээнтнийг өөрийн талд ойртуулан татахыг чухалчилж... Үүнийгээ Жибзундамбын санваарын багш Түвдийн Далай ламаар дамжуулан маш чадамгай гүйцэтгэж байв."* (24.37) гэж тухайн цагийн халх монгол Абахайн сүр хүчнээс эмээж, заль мэхэнд нь хууртсан монголын өмнөд хэсгийнхэн 1636 онд хойд Алтан улсад дагаар орсны дараа тусгаар байдлаа хадгалахын тулд Ойрадтай эв саналаа нэгтгэж, Манжийн түрэмгийллийг эсэргүүцэх тууштай бодлого баримталж байсныг сурвалжид тулгуурлан өгүүлжээ. Харин 1661 онд Засагт хаан Норов нас нөгчсөний дараа халхын баруун этгээдэд ноёдын өрсөлдөөн эхэлж, улмаар Түшээт хан Засагт хан хоёрын тэмцэл болж хувирсан юм. Энэ нь чухамдаа *"Жибзундамба хутагт Далай ламын хоорондох зөрөлдөөн байсан бөгөөд эцэстээ Түшээт хан ба Галдангийн хоорондох тэмцэл болон өрнөсөн байна"* (29.152) гэж 1953 онд монгол судлаач Таяама Шигейрү тэмдэглэсэн нь нилээд үнэмшилтэй мэт. Яагаад гэвэл Засагт хан нь Далай ламын дэмжлэг бүхий Галдантай худ ургийн хамааралтай, Жибзундамба хутагт Түшээт ханы төрсөн дүү байснаар тайлбарлагдаж байна. Гэхдээ тавдугаар дүрийн Далай лам Агваанлуvsанжамц халх, ойрадын самуун хурцдахаас өмнө 1682 онд таалал барьсныг дев лам Санжаажамц чанд нууцлан Түвдийн засгийн эрхийг ганцаараа эзэрхэж (23.345,28.1696) бүрлээч Далай ламын нэрээр өөрийн бодлогоо 15 жил хэрэгжүүлснийг ялгаж салгаж ойлгох хэрэгтэй.

Халхын дотоод байдал эгзэгтэй болсон тэр үед *"Түшээт хан түүний дүү Өндөр гэгээн нар Халхын тусгаар тогтносон байдлыг сахин үлдэх бодлогыг явуулж байсан мэт"* (24.45) гэж Ш.Нацагдорж абугайд дурдаад *"Галданг цөмрөн орж Халхыг бусниулах хүртэл манжид дагаж орох ямар нэгэн бодлого төлөвлөгөө байгаагүй"*

бололтой” (24.45) гэсэн таамаглалыг тэрбээр анх дэвшүүлжээ. Халх монгол манжид дагах болсон үндсэн шалтгаан бол Ойрад, халхын хямрал дээд цэгтээ хүрч, монголчууд өвөр зуураа хядалцсаар бүхэл үндэстэн сүйрч мөхөх их аюул гарцаагүй тулгарсан учраас халхын ноёд Манж, Орос хоёрын аль нэгээс дэмжлэг авах буюу өмөг түшигт нь багтахгаас өөр гарцгүй болсон байлаа. Тиймээс халхын ихэс дээдэс энэ тухай зөвлөлдөж, Өндөр гэгээнтний саналыг болгооход тэрбээр *“Орос бол шашин өөр тул Манжид дагаж орох нь сайн гэдэг зөвлөлгөө өгсөн”* (24.44) ажээ хэмээн урьд өмнө нь эрдэмтэн А.Позднеевийн тэмдэглэсэн мэдээг судалгааны эргэлтэд оруулсан байна. Гэвч хожмын түүхчид Ш.Нацагдорж академичийн эдгээр шинэ санааг төдий л хайхраагүй нь 1966, 1968, 1984, 2003 онд хэвлэсэн Монгол улсын түүхийн удаа дараагийн бүлээлүүдээс мэдэгдэж байна. Тухайлбал 1966 онд БНМАУ-ын түүх нэг боть зохиолд Өндөр гэгээнтний тухай дурдсан зүйл нь 1954 оны нэг ботид бичсэнийг хэвээр нь давтсан байна. (18.194) Мөн 1968 онд БНМАУ-ын түүхийн гурван боть зохиолын дэд ботид Монголчууд манжид дагаар орсныг улс төрийн өнгө аясаар тайлбарлаж *“халхын феодалууд тусгаар тогтнолоо хэрхэн сахин хамгаалах Галдантай яаж харьцах зэрэг амин гол асуудлын талаар олигтой хэлэлцсэнгүй. Харин Манж улсад дагаж орохыг хэлэлцсэн байна”* (8.91) Жибзундамба бол *“Манжийн Энх-Амгалан хааны улс төрийн бодлогод автагдсан этгээд байсан тул Манжид дагаж орохыг шууд зөвлөжээ.”* (8.92) Үүний уршгаар халх монгол манжийн эрхшээлд орсон юм гэж дүгнэжээ. Гэтэл тэр үед Ойрадын Галдан бошогт Алтайн нуруунаас Хөлөнбойр хүртэлх газрыг мэдэлдээ бүрэн авсан байлаа. Бүх нутгаа Галданд ийнхүү эзлүүлсэн халхчуудад хоёр л сонголт байсан бололтой. Тухайлбал хойд хөрш өмнө залгаа Манж хоёрын аль нэгийг нь өмгөөлөл хамгаалалд орох эсвэл Ойрадын дарангуйллыг хүлээхээс өөр боломжгүй байв. Иймээс дээр өгүүлсэнчлэн шашин нэгтэй, зарим зан үйл ойролцоо Манжийн хамгааллыг түр хүлээх нь арай оновчтой шийдэл байсан учир 1688 оны Ар элстэйн чуулган дээр шийдвэрийг гаргасан байна. Энэ нь 1660-аад оноос хойш гучаад жил үргэлжилсэн Монголын дотоод самуун буюу Халх, Ойрадын дайныг намжаах боломж бүрдүүлжээ.

Далаад оны сүүлчээр Өндөр гэгээнтний судлалд холбогдох сурвалжуудыг эрдэмтэд сонирхох болсон нь энэ чиглэлийн шинжилгээг гүнзгийрүүлэхэд дөхөм үзүүлсэн юм. Тухайлбал академич Ш.Бира 1978 онд Унгар улсад болсон эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэлдээ Халхын зая бандида Лувсанпэрэнлэйн түв

хэлээр туурвисан “Өндөр богдын цадиг оршивай” хэмээх бүтээлийг нилээд нарийвчлан авч үзсэн байна. Үүнээс хойш Өндөр гэгээнтний тухай судалгаанд гадаадын зарим шижээчид ч нилээд анхаарах болсны нэг жишээ бол Энэтхэгийн эрдэмтэн Рагу Вира, Локеш Чандра нарын бүтээл 1982 онд хэвлэгджээ. Ийнхүү 1962-80-аад оны эх хүртэлх хугацаанд Өндөр гэгээнтэн судлалд нилээд эрдэмтэд хувь нэмрээ оруулснаар зохих ахиц гарсныг судалгааны томоохон бүтээлүүдэд тусгаж эхэлжээ. Жишээ нь: 1984 онд Монгол Зөвлөлтийн эрдэмтдийн хамтран туурвисан “БНМАУ-ын түүх” зохиолын нэмж засварласан гурав дахь хэвлэлд Өндөр гэгээнтний тухай хуучны хэвшмэл ойлголтыг арай эерүүлж халхын ноёд 1688 онд “*Өндөр гэгээнтний саналаар тусгай хуралдан Манж улсын түшиг хамгаалалд орох шийдвэр гаргажээ*” (9.223) хэмээн дүгнэсэн байна.

Үүнээс хойш 1990-ээд оны эх хүртэл Өндөр гэгээнтний улс төрийн үйл ажиллагааг хөндсөн бүтэл гараагүй бололтой. Харин ардчилал эхэлснээр Монголын эх түүхийн аль ч сэдэв, асуудлыг чөлөөтэй судлан шинжлэх болсноор Өндөр гэгээнтний намтар, шашин, улс төрийн үйл ажиллагаа, урлаг, хэл шинжлэлийнх нь өвийг тодруулан судлахад олон хүн анхаарч нилээд бүтээл туурвижээ. Ялангуяа 1995 онд Гэгээнтний мэндэлсний ойг тэмдэглэх үеэр зохиосон эрдэм шинжилгээний хуралд түүхч, хэлний шинжлэлтэн, лам хувраг хэд хэдэн хүн сонирхолтой шинэ санаа дүгнэлттэй илтгэл хэлэлцүүлсэн байна. Тухайлбал доктор, проф. Л.Хүрэлбаатар тавьсан илтгэлдээ Өндөр гэгээнтэн бол “*Монголын шашин, төрийн нэрт зүтгэлтэн, соён гийгүүлэгч*” гэж дүгнээд Занабазар, Галдан нарын судалгаанд энэ хоёрын нэгийг нь “*урвасан дагасан*” нөгөөг нь “*баатарлагаар тэмцсэн*” хэмээн бичиж байгаа нь ул суурьтай судалгааны үр дүн бус “*түүх бичлэгийн цоорхой*” (25.20) гэж тодорхойлоод “*хийсвэр сэтгэлийн хөөрлөөр өнгөц магтах, эсвэл үгүйсгэн шүүмжлэх хоёр хэтийдлийн халилаас ангид үнэнхүү голын төв ёсонд*” (25.25) суурилсан судалгаа хийх шаардлагатайг цохон тэмдэглэсэн нь гэгээнтэн судлалын бүх сэдэвт анхаарууштай зөв санаа байлаа.

Доктор, профессор Н.Хавх илтгэлдээ халх монголчууд Манжийн хамгааллыг хүссэн нь “*тэр хүнд ээдрээтэй түүхэн нөхцөлд монгол үндэстнээ аварч гарах холын хараатай төрийн зүтгэлтэн хэн ч бай сонгон авах нь гарцаагүй бараг цорын ганц шахуу зам байвуу*” (25.53) гэж тэмдэглэснийг дэмжиж байна.

Эрдэмтэн багш Ш.Сонинбаяр "Өндөр гэгээнтэн дан ганц шашин номын мөр хөөсөн лам хувраг байсангүй тухайн үеийн улс төрийн амьдралд идэвхтэй оролцож өөрийн зохиосон хос ёс, гүн ухаан, энх тайвныг эрхэмлэсэн сургааль зарлигаараа ард түмний оюун санаанд үлэмжхэн нөлөөлж байлаа" (25.124) хэмээн түүний олон талт үйл ажиллагааг тодорхойлоод зэвсэгт цэрэг "халдаар орж ирэхэд арга буюу буруулан ухарч тулгаран тулалдахыг хүсэлгүй асрах, энэрэх, шашны гүн ухаанаар олон түмний амь биеийг хамгаалж түр нэг удаа манжийг түшихээр шийдсэн" (25.122) байна хэмээн дүгнэсэн юм. Энэ бол монголын түүх бичлэгт урьд өмнө нь төдий л гараагүй шинэ санаа, сонирхолтой эргэцүүлэл байв. 16-р дүрийн Жибзундамба хутагт ертөнцийн жамаар жанч халаагүй хэмээн зарим түүхчид тэмдэглэсэн байдгийг Сонинбаяр ламтан лавшруулан тодруулж түүний "шадар сойвон Шаравдорж мэс өргөснөөр Өндөр гэгээн... таалал төгсөж бие лагшныг номын чанарын агаараар хураах ёсыг үзүүлжээ" (25.129) хэмээн дурдсаныг цаашид гүнзгийрүүлэн судалж тэр аугаа их хүн тухайн цагтаа улс төрийн золиос болж амь насаараа хохирсныг тодруулуштай.

1995 онд болсон эрдэм шинжилгээний энэхүү хурал Өндөр гэгээнтэн судлалд хувь нэмэр болохуйц олон илтгэл хэлэцсэний заримаас нь товч өгүүллээ. Бусад илтгэлүүдэд олон шинэ мэдээ, санаа дүгнэлт байгааг энд хамруулж амжсангүй. Харин манай судлаачид Өндөр гэгээнтний тухай эрдэмтдийн дэвшүүлсэн шинэ санаа дүгнэлт, гаргалгааг төдий л анзаарахгүй байгаа нь харамсалтай. Тухайлбал: 2003 онд хэвлэсэн "Монгол улсын түүх" таван боть зохиолын дөтгөөр ботид Өндөр гэгээнтний тухай бичсэн зүйлийн талаар зориуд цохон хэлье. Манай түүхчдийн хамгийн тог бөгөөд шинэ бүтээл болох энэхүү таван ботид судлаачдаас Өндөр гэгээнтний тухай дэвшүүлсэн санаа дүгнэлтийг хайхраагүйгээр үл барам 1990 оноос өмнөх хуучинса ойлголтыг төдий л өөрчлөөгүй байна. Тухайлбал уул зохиолд Ар элстэйн чуулганы шийдвэр бол "Халхын бүх ноёд, нийт олных бус харин эрх баригч цөөн хэдэн хүний гаргасан шийдвэр юм" (21.119) гэж дурдсан нь түүхэн үйл явдалд хэт эдүгээчлэл байдлаар хандсан гэж үзэхэд хүргэж байна. Учир юун гэвэл тэр хүнд бэрх цаг тулгамдсан асуудлыг бүх ард иргэдээрээ хэлэлцүүлэх ямар ч боломж байгаагүй тайлбарлах нь илүүц юм. Ер нь дээрх чуулганы шийдвэрийг сайтар ажиглах юм бол бидний хуучин төсөөллөөс арай өөр зүйл ч мэдэгддэг. Жишээ нь: тэрхүү чуулган оролцогчдын зарим нь өвөрлөгчдийн адил Манж дайчин улсад шууд дагаар ор

гэсэн бол нэг хэсэг нь зөвхөн өмөг түшигт нь багтъя хэмээсэн саналтай байжээ. Харин Өндөр гэгээнтэн би халхын ноёдын өмнөөс бүх зүйлийг *“төлөөлж айлтгахад дөхөмгүй”* (3.79) хэмээн айлджээ. Гэвч олонхийн саналаар дагаар орох хүсэлтээ өргөн мэдүүлсэн байна. Энэ бол Өндөр гэгээнтэн тэр үед Халхын бүх ноёдыг албадан шахаж манжид дагаар оръё хэмээн дураараа аашлаагүйг нотлож байна. Нөгөө талаар зарим судлаачдын бичсэнчлэн 1630-аад оноос хойш *“нийт халхыг төлөөлөх эрх хэнд ч байсангүй гагцхүү шашны эрх ямбаар Занабазар л хамгийн нөлөөтэй нь байлаа”* (2.103) тиймээс бусад ноёд өөрсдийн саналаа Гэгээнтэнд айлтгаж харилцан зөвлөлдсөн нь учир зүйн хэрэг билээ. Үүнтэй холбогдуулж хэлэхэд улирч өнгөрсөн түүхийн ямар ч сэдэв асуудлыг судлахдаа эдүгээчлэх, улс төрийн үзэл хандлагад дулдуйдахаас ямагт зайлсхийж гагцхүү сурвалж баримтанд тулгуурлан голч байр сууринаас ханддаг түгээмэл зарчмыг 90 оноос өмнө түүхчид бид төдий л хайхардаггүй байсан нь одоо ч бүрэн үгүй болоогүйг тэмдэглэх нь зүйтэй. Өндөр гэгээнтний улс төрийн үйл ажиллагааг ултай шинжлэхийн тулд заавал үзэж судлах нилээд бүтээл бий. (4-6,10-15,17,19,20,26,31), Ялангуяа манж, монгол болон бусад хэл дээр байгаа сурвалжуудыг үзэхгүйгээр гэгээнтэн судлалд ахиц гарах боломжгүй. Гэхдээ тэдгээр сурвалжийн заримыг манж хятад түүхчид цаг үеийн шаардлагаар зориуд засварлан бодит байдлыг гажуудуулсан байж болзошгүйг анхаарах нь мэдээж билээ. Ер нь сурвалжид тулгуурлахгүй мэдэмхийрэх болсны уршгаар түүхийн үнэнийг гуйвуулахад хүрдгийн жишээ бол 1993 онд хэвлэгдсэн хоёр боть бүхий нэгэн бүтээлд Өндөр гэгээнтэн 1640 онд Или Тарвагатайд болсон монгол ойрадын их чуулганд оролцсон мэтээр хэт ташаарсан байна (1.983).

1911-2004 он хүртэлх хугацаанд Монголын судлаачид Өндөр гэгээнтний улс төрийн үйл ажиллагааг хэрхэн авч үзсэн тухай хураангуй өгүүлэхэд ийм байна. Цаашид Өндөр гэгээнтэн судлалыг гүнзгийрүүлэхийн тулд хойш тавилгүйгээр ойрмог үед хийх зарим ажил байгааг хэлэх нь зүйтэй. Тухайлбал XVII-XX зууны эхэнд туурвисан Өндөр гэгээнтний намтар зохиол нилээд хэд байдаг боловч эдүгээ олж ашиглах боломж хязгаарлагдмал учир тэдгээрийг эхээр (факсимиле)-ээр нь хэвлүүлэх, мөн Өндөр гэгээнтний холбогдолтой монгол, манж, хятад бусад хэл дээр байгаа сурвалжийг эмхтгэж хэвлүүлэхээс гадна энэ чиглэлийн ном зүйн бүртгэлийг бэлтгэж гаргах нь чухал байна. Мөн Өндөр гэгээнтэн судлалаар мэргэшсэн буюу сонирхдог судлаачдыг хамруулсан эрдэмтдийн хамтлаг байгуулж түүний бүх үйл

ажиллагаа, бүтээл туурвилыг ялангуяа тэрбээр монголын улс төрд гүйцэтгэсэн үүрэг, эзлэх байр суурийг тодруулан судлаж голч дүгнэлт гаргах явдал тулгамдсан зорилт болж байгааг түүхчид судалгааны хүрээлэнгүүд хугацаа алдахгүйгээр эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлан шийдвэрлүүлэх нь зүйтэй. Энэ нь монголын эх түүхийг бүрэн боловсруулахад ч зохих тус дөхөм болох ёстойг хэн ч үгүйсгэхгүй буй за.

Abstract : Various Mongolian and international historians have been studying the biography and activities of a prominent Mongolian religious and political figure of 17th and 18th centuries -Zanabazar, the first Bogd Khan. During 1929 to 1990s Mongolian researchers used to study the biography of Zanabazar from the Marxist conception and perception. However, since 1990s his activities have been studied from the pluralist points of view which intensified the understanding about Zanabazar. Nonetheless there are vital needs for doing more studies about Zanabazar in cooperation with international scientists, which this article briefly describes about.

Ном зүй

1. Алтанша Н.Монголчуудын өчигдрийн мөр. ӨМСХХ. Улаан хад 1993
2. Баавар. XX зууны Монгол. Нүүдэл. Суудал.Олз. Гарз. УБ.1996
3. Биеэр дайлж өрнө умрын газрыг төвшитгэн тогтоосон бодлогын бичиг ӨМСХХ. Хөлөн Бойр 1992
4. Богд гэгээнбээр Халх Монголын оронд анх хувилж шашныг дэлгэрүүлэн төр дааж сайтар үзүүлэн амьтныг жаргуулан айлдсан цадиг орошив. (Гар бичмэл)
5. Богд Жибзундамбын анхан төрлийн нэр оршивай. Орон дацан анхан байгуулсныг бичсэн буянаар бурхны шашин өнө үүрд орших болтугай-Монгол Улсын шастир II УБ 1997. 86-103
6. Буянчуулган Б.Манж Монголын холбогдсон түүхт байдал
7. БНМАУ-ын түүх УБ 1955
8. БНМАУ-ын түүх,Дэд боть.1604-1917. УБ 1968
9. БНМАУ-ын түүх, Нэмж засварласан гуравдахь хэвлэл УБ 1984
10. Галдан. Эрдэнийн эрх УБ 1960
11. Дайчин улсын тулгур төрийг нээсэн бодлогын бичиг

12. Дайчин улсын шензү хааны магад хууль
13. Дээрхийн уг эх (Гар бичмэл)
14. Жибзундамба ламын төрөл үеийн нэрс хийгээд орон дацан байгуулсан тэмдэглэл (Гар бичмэл)
15. Жибзундамба Лувсанчойжижалцансамбуугийн ердийн товч намтар. (Буриадын Ага-ын дацангаас олдсон)
16. Зарлигаар тогтоосон монгол улсын хууль зүйлийн бичиг УБ 1995
17. Лувсанпэрэнлэй (Заябандида). Өндөр Богдын цадиг оршив (Гар бичмэл)
18. История МНР М. 1967
19. Локеш Чандра. Анхдугаар богд Жибзундамбын амьдрал ба бүтээлүүд. Дели 1982. (Англи хлээр)
20. Лувсанринчин Дээд шашин эрдэнэбээр Монгол орныг түгээлүүлсэн үгийг үзүүлсэн яруу хэлний хүрхрэл нэрт оршив. 1832. (Бар хэвлэл)
21. Монгол Улсын Түүх. Дөтгөөр боть (XVII-XX зууны эхэн) 2003
22. Монгол Улсын шастир I-II боть УБ 1997-
23. Монгол үндэстний нэвтэрхий түүх (Дээд , дунд, доод) Бээжин 1995
24. Нацагдорж. Ш. Манжийн эрхшээлд байсан үеийн халхын хураангуй түүх. (1691-1911) УБ 1963
25. Өндөр гэгээн Занабазар. Эрдэм шинжилгээний бичиг. УБ. 1998
26. Өндөр гэгээний уг эх хийгээд тэр үеийн манжийн хаадын зарлиг тушаал мэтийн чухал хэрэг зүйлийг цуглуулан бичсэн дэвтэр (Гар бичмэл)
27. Пэрлээ. Х. Монголын хувьсгалын өмнөх үеийн түүх бичлэгийн асуудалд УБ 1958
28. Содбилиг. Шашны толь. ӨМСХХХ Түнлиёо 1996
29. Таяама Шигейрү. Чин улсын үе дэх Монголчуудын нийгмийн байгуулал. ӨМСХХ. 1988.
30. Чимэд .Ө. Эрдэнийн очир одон УБ. 1961
31. Эрдэнэ зуу, Өндөр гэгээний намтар гар бичмэл (Улсын Төв Номын Сан)